



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ТОГТООЛ

2024 оны 11 сарын 14 өдөр

Дугаар 567

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгийн ашиглах хугацааг сунгах,
үнийг шинэчлэн тогтоох зөвшөөрөл олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 31 дүгээр зүйлийн 1, 3 дахь хэсэг, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 7.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1.Боловсролын судалгааны үндэсний хүрээлэнгийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн боловч цаашид ашиглах боломжтой, 15 нэрийн, нийт 64,324,036.00 (жаран дөрвөн сая гурван зуун хорин дөрвөн мянга гучин зургаа) төгрөгийн балансын үнэ, хуримтлагдсан элэгдэл бүхий хөрөнгийн ашиглах хугацааг сунгаж, нийт үнийг 25,729,614.40 (хорин таван сая долоон зуун хорин есөн мянга зургаан зуун арван дөрвөн төгрөг дөчин мөнгө) төгрөгөөр хавсралтад заасны дагуу шинэчлэн тогтоохыг зөвшөөрсүгэй.

2.Боловсрол, шинжлэх ухааны яамны Төрийн нарийн бичгийн дарга Х.Батжаргал, Боловсролын судалгааны үндэсний хүрээлэнгийн захирал М.Итгэл нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1.Байгууллагын өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор хавсралтад заасан хөрөнгийн ашиглах хугацааг сунгах, үнийг шинэчлэн тогтоох ажлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулах;

2.2.Хөрөнгийн хөдлөлийг холбогдох хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх системд”-д бүртгэх;

2.3.Арга хэмжээний биелэлтийг 2025 оны 1 дүгээр улиралд багтаан ирүүлэх.

3.Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.

ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛ,
АШИГЛАЛТЫН ХЭЛТСИЙН ДАРГА

Д.НАРАНГЭРЭЛ

132002447
26-r huraldaan.docx

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2024 оны 12 дугаар сарын 18-ны өдрийн
26.7 дугаар тогтоолын хавсралт

БОЛОВСРОЛЫН СУДАЛГААНЫ ҮНДЭСНИЙ ХҮРЭЭЛЭНГИЙН ҮНДСЭН ХӨРӨНГӨД БҮРТГЭЛТЭЙ, ҮЛДЭГДЭЛ ӨРТӨГТҮЙ,
АШИГЛАХ ХУГАЦААГ СУНГАЖ, ҮНИЙГ ШИНЭЧЛЭН ТОГТООХ ХӨРӨНГИЙН ЖАГСААЛТ

Д/д	Хөрөнгийн нэр, төрөл	Ашиглалтанд орсон огноо	Нэг бүрийн үнэ (төгрөг)	Тоо хэм жээ	Нийт балансын үнэ /хуримтлагдсан элэгдэл/ (төгрөг)	Шинэчлэн тогтоох үнэ (төгрөг)		Цашид ашиглах хугацаа /жилээр/
						Нэг бүрийн үнэ (төгрөг)	Тоо хэм жээ	
1	Камер аппарат	2020-12-31	588,632.00	1	588,632.00	235,452.80	1	235,452.80
2	Шарах шүүгээ	2020-12-31	21,318.00	5	106,590.00	8,527.20	5	42,636.00
3	Зөөврийн компьютер	2020-12-31	259,980.00	1	259,980.00	103,992.00	1	103,992.00
4	Факст А4 принтер.	2020-12-31	103,378.00	2	206,756.00	41,351.20	2	82,702.40
5	Канон	2020-12-31	464,376.00	1	464,376.00	185,750.40	1	185,750.40
6	Хөгжим апаратур.	2020-12-31	1,332,848.00	1	1,332,848.00	533,139.20	1	533,139.20
7	ЛСД дэлгэц 1980,0	2020-12-31	792,000.00	1	792,000.00	316,800.00	1	316,800.00
8	Ус цэвэршүүлэгч 499.9.	2020-12-31	199,960.00	4	799,840.00	79,984.00	4	319,936.00
9	Хөргөгч.	2020-12-31	246,356.00	5	1,231,780.00	98,542.40	5	492,712.00
10	Сервер 2022	2020-12-31	4,440,000.00	1	4,440,000.00	1,776,000.00	1	1,776,000.00
11	Принтер яам	2018-11-30	418,000.00	4	1,672,000.00	167,200.00	4	668,800.00
12	Компьютер dell vostro	2018-12-19	1,990,747.00	22	43,796,434.00	796,298.80	22	17,518,573.60
13	Кофе чанагч	2018-12-31	629,900.00	1	629,900.00	251,960.00	1	251,960.00
14	Хөргөгч sharp	2018-12-31	849,900.00	1	849,900.00	339,960.00	1	339,960.00
15	Номын шкаф.	2013-12-31	311,000.00	23	7,153,000.00	124,400.00	23	2,861,200.00
	НИЙТ ДҮН		12,648,395.00	73	64,324,036.00 (жаран дөрвөн сая гурван зуун хорин дөрвөн мянга гучин зургаа)	5,059,358.00	73	25,729,614.40 (хорин таван сая долоон зуун хорин есөн мянга зургаан зуун арван дөрвөн төгрөг дөчин мөнгө)